

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2022/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Уранбилэг Утас: 70523020 Цахим хаяг: uranbileg.b@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Ауд. од. 25 № 1-6/2025
танай _____-ны № _____-т

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ОЮУНСАЙХАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	112.3	152.9
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	777.8	734.3
	Нийт хөрөнгийн дүн	890.1	887.2
	Нийт өр төлбөрийн дүн		0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		887.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	890.1	887.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	726.5	699.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	742.2	697.0
	Үйл ажиллагааны үр дүн	(15.7)	2.6
	Үйл ажиллагааны бус үр дүн	(7.0)	(5.5)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(22.7)	(2.9)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл		890.1
	Тайлант оны үр дүн		(2.9)
	Эцсийн үлдэгдэл	890.1	887.2
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	717.5	759.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	654.7	713.5
	Үйл ажиллагааны ЦМГ	62.8	46.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		459.4
	Урсгал зардал		413.9
	Хөрөнгийн зардал		45.5
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		459.7
	Улсын төсвөөс санхүүжих		446.1
	Орон нутгийн төсвөөс		13.6

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын эрхэм зорилго: Газрын харилцаа, барилгын салбарын багц хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт үр дүнтэй зохион байгуулж, газрын шинэтгэлийн бодлогыг эрчимжүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, барилга хот төлөвлөлтийн үйл ажиллагааг орчин үеийн мэдээллийн технологид түшиглэн иргэдийн амьжиргааны түвшнийг сайжруулахад чиглэсэн үйлчилгээг нээлттэй, шуурхай үзүүлэх төрийн байгууллага байна.

Үйл ажиллагааны чиглэл

Дорноговь аймгийн хөгжлийн чиг хандлагыг зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд нийцүүлэн зөв тодорхойлоход аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, аймгийн газрын харилцаа болон барилгын, хот байгуулалтын асуудлыг хууль тогтоомжийн дагуу, шинжлэх ухааны үндэслэлтэй зохицуулахад аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ажил үндсэндээ чиглэгдэж байгаа юм.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд шинжилгээний болон барилгын техник хяналтын зардлын нийт 266.0 сая төгрөг төвлөрсөн байна. Үүнээс 50.0 сая төгрөгийг дээд шатны байгууллагад шилжүүлж, 124.7 сая төгрөгийг зарцуулсан байгаа ба үүнээс 52.3 сая төгрөгийг БХБС-ын 2019 оны 85 дугаар тушаалаар батлагдсан улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд хийх захиалагчийн хяналтыг зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрлөөс бусад зардалд зарцуулж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант онд ГЗБГЗЗГ-аас 3.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авч, бүртгэж, тайлагнасан байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 261.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 209.1 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгах тухай 1 зөвлөмж, 52.3 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгөв.

4.1 Залруулсан алдаа

1. Санхүүгийн тайлан өглөггүй гэж тайлагнасан боловч аудитын явцад Чандмань илч ХХК-тай тооцоо нийлэхэд 16,799.89 төгрөгийн өглөгтэй байгааг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 20.0 сая төгрөгөөр хөрөнгө худалдан авсан байтал мөнгөн гүйлгээний тайланд тусгагдаагүй байна.
2. Тайланд оны мөнгөн гүйлгээний журналыг зардлын данс бүрээр шалгахад нийт 209.1 сая төгрөгийн 322 ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэсэн байна.

Албан шаардлага

1. Тайлант онд нийт 45.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан байна. Үүнээс 37.2 сая төгрөгөөр компьютер худалдан авсан байгаа ба худалдан авалтыг 0.7-15.5 сая төгрөгийн шилжүүлгээр худалдан авсан байна. Худалдан авах хөрөнгийн үнийн судалгаа байхгүй, техникийн тодорхойлолт байхгүй, холбогдох хууль тогтоомжид заагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
2. Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого буюу шинжилгээний орлого 4.3 сая төгрөг, барилгын захиалагчийн хяналтын зардлаас 261.7 сая төгрөгийг төвлөрүүлэн, 124.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс 52.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь БХБС-ын 2013 оны 85 дугаар тушаалаар батлагдсан улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд хийх захиалагчийн хяналтыг зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрлийг зөрчиж байна.
3. Тайлант хугацааны эцэст БЗӨБЦТС ТӨХК Дорноговь ЦТСС, Чандмань илч ХХК-тай тооцоо нийлж, бусад харилцагч байгууллагуудтай тооцоо нийлээгүй, өглөг авлагыг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

4.3 Зөвлөмж

Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн журналыг шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 259.4 сая төгрөгийн өртөгтэй 143 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно", 31.3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар

ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасны дагуу тодорхой ажил зохион байгуулж, шийдвэрлэх.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	6	261.4	2	209.1			3	52.3	1	
1	ТШЗ	6	261.4	2	209.1			3	52.3	1	
	НИЙТ	6	261.4	2	209.1			3	52.3	1	